



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/24

Бор-Өндөр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, Бор-Өндөр сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2026 онд хийгдэх “Оюуны уурхай сургуулийн анги засварын ажлын дагалдах хэрэгсэл худалдан авах” ажлын санхүүжилтийн үлдэгдэл болох 2,619,000 (хоёр сая зургаан зуун арван есөн мянга) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зарцуулсугай.

2.Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зохих хууль дүрэм, журмын дагуу зарцуулахыг санхүүгийн албаны дарга /Э.Түвшинсайхан/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ